



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

**Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны А/239 дүгээр тушаал, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 134 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2018 оны А/41 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Болзошгүй гамшгийн аюулаас хүн, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын томилгоот бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах, гамшгийн үеийн хүч хэрэгслийн харилцан ажиллагааг сайжруулах, гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдалд шалган туслах үзлэгт хамрагдах 100 аж ахуйн нэгж, байгууллагын нэрсийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар, удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бэлэн байдлын үзлэг шалгалтыг явуулахад шаардагдах зардалд 4,649,880 /дөрвөн сая зургаан зуун дөчин есөн мянга найман зуун наян мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ахлах нягтлан бодогч /Б.Хонгорзул/-д зөвшөөрсүгэй.

3. Бэлэн байдлын үзлэгт шаардагдах бэлтгэл ажлыг хангуулж ажиллахыг холбогдох байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож, танилцуулж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс /А.Батмөнх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА